

## МУБИС-ИЙН МЭРГЭЖЛИЙН БУС АНГИЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН СТАНДАРТ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Н.Мөнхбаяр, Т.Уянга  
МУБИС-ийн НХУС-ийн Гадаад хэлний төвийн багш

**Abstract:** In this article we have tried to explain how curriculum innovation has been done for Non-English Major students at Mongolian National University of Education. English course for Non-English Major students consisted of General English and ESP. When we design ESP curriculum we should conduct needs analysis of students and the curriculum should be based on this analysis. The differences between General English and ESP can be explained by students' needs and demands. In order to meet the needs of students' future workplaces and society, the need to learn English for Special Purposes has been growing. ESP training must be based on General English Training and students who attend ESP programs ought to have an intermediate or upper-intermediate level of English language knowledge and competence. Therefore, General English Training curriculum must be upgraded to improve learner's language skills and then ESP training curriculum will commence to improve their competencies across the four language skills plus competency in translation.

**Түлхүүр үг:** хэлний бус ангийн англи хэлний сургалт, оюутнууд, хөтөлбөр, тусгай зориулалтын англи хэл

Манай орны англи хэлний сургалт нь жилээс жилд улам боловсронгуй болж байгаа хэдий ч сайжруулах асуудлууд байсаар байна. Нэн ялангуяа их, дээд сургуулиудын англи хэлний сургалтын хөтөлбөр, стандартын талаар нэгдсэн ойлголт байхгүй, сургалтын хөтөлбөрийг боловсруулах арга техник нь хоцрогдсон зэргээс болж сургалтын чанар

орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байна. Оюунцэцэг, 2011 “Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн асуудал нь хөтөлбөр боловсруулж байгаа арга, сургалтын хөтөлбөрийг боловсруулахад оролцож байгаа болон удирдан явуулж байгаа багш нарын мэдлэг чадвараа дээшлүүлж байгаа байдал, тэдгээрт нийгмийн зүгээс үзүүлж байгаа харилцаа, хамтын ажиллагаа гэсэн гурвалсан ойлголтыг нэгэн зэрэг авч үзэх асуудал юм”.(х.99)

Монгол улсын хувьд 1998 онд англи хэлний сургалтын анхны стандартыг боловсруулан хэрэгжүүлсэн нь сургалтын агуулга, арга зүйг нэгтгэн цэгцэлж, улсын хэмжээнд англи хэлний боловсролын тогтолцоог бий болгоход чухал хувь нэмэр оруулсан ба их, дээд сургуулиуд ерөнхий англи хэлний сургалтыг энэхүү стандартад нийцүүлэн зохион байгуулж эхэлжээ. Бусад орны жишгээс харахад тухайн хичээлийн стандарт, хөтөлбөрийг Боловсролын асуудал хариуцсан яамнаас ерөнхийд нь чиглүүлэн гаргаж өгдөг ба хэрэгжүүлэгч байгууллага болох их, дээд сургуулиуд түүнд үндэслэж өөрсдийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах байдлаар сургалтаа зохион байгуулдаг байна. Манай орны хувьд бага, дунд сургуулийн англи хэлний сургалтын хөтөлбөрийн талаар боловсролын яамнаас ерөнхий чиг гарган өгдөг боловч их, дээд сургуулиудын хувьд өөрсдөд нь даалган орхидог гэж үзэж болно.

Английн судлаач Н.Таба (1962) англи хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулах шат дарааллыг дараах байдлаар тодорхойлсон байна. Англи хэлний



сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц нь:

1. Суралцагчдын хэрэгцээг тодорхойлох
2. Сургалтын хөтөлбөрийн зорилгыг оновчтой тодорхойлох
3. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг тодорхойлох
4. Агуулгын бүтцийг тодорхойлох
5. Заах арга зүйн асуудлыг оновчтой болгох
6. Үнэлгээг боловсронгуй болгох гэсэн үе шатлалтай байна.

Англи хэлний сургалтын хөтөлбөр боловсруулахад хамгийн түрүүнд тухайн хөтөлбөр хэрэгжсэнээр хүрэх зорилгыг оновчтой, зөв тодорхойлох нь чухал болно. Харин өнөөдрийн байдлаар манай их, дээд сургуулиудын англи хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулах зорилготой ажилладаг нэгдэл эсвэл ажлын хэсэг аль аль нь байхгүй, зөвхөн тухайн сургуулийн багш нар сургуулийн хэрэгцээнд зориулж, англи хэлний хөтөлбөрийг боловсруулж байгаа нь учир дутагдалтай байна.

Ерөнхий англи хэлний зэрэгцээ мэргэжлийн чиглэлийн англи хэлний хэрэгцээ өссөн, өөрөөр хэлбэл өөрийн мэргэжлийн хүрээнд хэрэглэгдэх англи хэлийг судлах хүсэлтэй суралцагчдын тоо олноор бий болж “Англи хэл сурах ямар хэрэгцээ байна, тэрхүү хэрэгцээнд нь тохируулж сургалтыг зохион байгуулах” гэсэн онол гарч ирлээ. Харин мэргэжлийн чиглэлийн англи хэлний стандарт хөтөлбөрийн талаар боловсролын яамны зүгээс ямар нэгэн тусгайлсан чиг баримжааг өгдөггүй. Энэ нь нэг талаас мэргэжлийн чиглэлийн англи хэл нь шинэ тутам бий болж байгаа англи хэлний боловсролын салбар гэдэгтэй холбоотой ч нөгөө талаас мэргэжлийн чиглэлийн англи хэлний хичээлийг заах нь багшаас хөдөлмөр, цаг хугацаа их шаарддаг гэдгийг онцлон хэлэх нь зүйтэй. Учир нь мэргэжлийн чиглэлийн англи хэл нь олон салбарыг хамарсан ойлголт тул тэдэнд бүрэн тохирсон сурах бичиг, материал гэж байдаггүй.

МУБИС-ийн Гадаад хэлний төв нь мэргэжлийн бус ангийн англи хэлний сургалтыг хариуцан 50 гаруй төрлийн мэргэжлээр суралцаж буй 3000 орчим оюутан суралцагчдад ерөнхий англи хэл

ба мэргэжлийн чиглэлийн англи хэл гэсэн 2 төрлөөр сургалтын үйл ажиллагаагаа явуулдаг. Сургалтын хөтөлбөрийн хувьд ерөнхий англи хэлний хөтөлбөрийг оюутнуудын англи хэлний түвшинг харгалзан үзэж E1- (дундаас доогуур түвшин), E2- (дунд түвшин) гэсэн 2 өөр хөтөлбөрийг багш нар өөрсдөө боловсруулж байгаагийн зэрэгцээ E3 - (мэргэжлийн англи хэлний хөтөлбөр), E4- (магистрантурын сургалтын хөтөлбөр), E5- (докторантурын сургалтын хөтөлбөр)-ийг боловсруулан сургалтаа явуулж байгаа нь англи хэлний сургалтын хөтөлбөрт гарч байгаа томоохон шинэчлэл гэж бид үзэж байна.

### Хүснэгт 1

Мэргэжлийн англи хэлний хөтөлбөрийг хичээл тус бүрээр боловсруулсан байдлаар нь үзүүлбэл

№	Мэргэжлийн англи хэл үзэж буй мэргэжлийн чиглэлүүд	Хөтөлбөрийн тоо
1	Түүх, философи, аялал жуулчлал, уран зохиол	4
2	Математик, мэдээлэл зүй	2
3	Дүрслэх урлаг технологи	1
4	Нийгмийн ухаан	1
5	Байгалийн ухаан	1
6	Биеийн тамир	1
7	Эрдмийн англи хэл	2
	Нийт	12

Одоогоор нийт 50 орчим мэргэжлээс 12 мэргэжлийн чиглэлийн англи хэлний хөтөлбөрийг боловсруулаад байгаа ба үлдсэн 38 орчим мэргэжлийн англи хэлний хөтөлбөрийг боловсруулах шинэчлэлийн ажил хийгдэж байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд англи хэлний сургалт эрчимтэй хөгжиж ирсэн ба энэ хугацаанд боловсролын яамны зүгээс ерөнхий англи хэлний стандартыг хэд хэдэн удаа боловсруулсан боловч мэргэжлийн англи хэлний сургалтын стандарт гэж тусгайлсан стандарт өнөөг хүртэл байхгүй байна. Харин оюутан суралцагчдыг мэргэжлийн чиглэлээрээ ном сурах бичиг, холбогдох материалуудыг англи хэл дээр унших чадвартай байх, судалгаа шинжилгээний ажилдаа англи хэлийг

ашигладаг байх, англи хэлний олон улсын дундаж түвшинд хүрсэн байх зэрэгтэй холбоо бүхий олон заалт гаргасан байдаг.

МУБИС-ийн гадаад хэлний төвийн англи хэлний сургалтын хувьд нэгдүгээр курсийн оюутнууд ерөнхий англи хэлний заавал судлах 3 кредит, хоёрдугаар курсийн оюутнууд мэргэжлийн чиглэлийн англи хэлний сонгон судлах 3 кредит хичээлийн хөтөлбөрийн дагуу орж байна. Багш нарын хувьд нэг хэсэг нь академик англи хэлийг заах нь зүйтэй гэж үздэг байхад нөгөө хэсэг нь багш бэлтгэдэг сургууль учраас “багш” мэргэжлийн англи хэлийг заах нь зүйтэй гэсэн саналтай байдаг төдийгүй дээрх хөтөлбөрийн боловсруулалтын байдалд анализ хийж үзэхэд ерөнхий англи хэл, мэргэжлийн чиглэлийн англи хэлний хөтөлбөр дээр суурилсан сургалт давамгайлж байна.

Энэхүү байдал нь манай орны бусад их, дээд сургуулиудын хувьд ч өөр өөр байдлаар тусгагдсан байдаг ба тухайлбал МУИС-д нийт оюутан суралцагчдыг англи хэлний сургалтын хувьд дундаас дээгүүр түвшинтэй байхыг шаардаж академик англи хэлний хөтөлбөрийг санал болгодог байхад ШУТИС-ийн хувьд оюутанд мөн дундаас дээгүүр түвшинтэй байх шаардлага тавьж, мэргэжлийн чиглэлийн англи хэл, тэр дундаа шинжлэх ухаан технологийн англи хэлний сургалтын хөтөлбөрийг санал болгодог. Их, дээд сургуулиудын англи хэлний хөтөлбөрийн хувьд бид ямар төрлийн англи хэлний хөтөлбөр дээр суурилсан сургалт явуулах вэ? гэдгийг цаашид судалгаа хийж бусад орны туршлагаас хуваалцах хэрэгтэй хэмээн үзэж байна.

Мэргэжлийн чиглэлийн англи хэлийг олон улсын түвшинд дундаас дээгүүр түвшинтэй оюутнуудад заах шалгууртай байдаг ба дээрх сургуулиудын хувьд оюутнуудын англи хэлний мэдлэгт тодорхой шалгуур тавьж байгаа нь зөв зүйтэй асуудал юм. Цаашид дунд сургууль болон их, дээд сургуулиудын хоорондын залгамж холбоог сайжруулж тухайн суралцагч дунд сургууль төгсөх үедээ дунд шатанд хүрэхүйц англи хэлний мэдлэгтэй байна гэсэн шалгуур тогтоохгүй бол их, дээд

сургуульд элсэн орж ирж буй оюутнууд англи хэлний мэдлэг муутай байгааг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй байна. Үүний улмаас их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг оюутны хэрэгцээ шаардлага болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулах боломжгүй болдог, өөрөөр хэлбэл мэргэжлийн чиглэлийн англи хэлний хөтөлбөрийн дагуу сургалт явуулах боломжгүй болж байна.

Бусад орны жишгээс харахад их, дээд сургуулиуд нь нарийн шаталсан хөтөлбөрөөр англи хэлний сургалт явуулдаг ба англи хэлний хичээл заах багш нараа хүртэл ангилж өгдөг. Тухайлбал, Солонгосын олон улсын их сургууль (International University of Korea)-г авч үзье. Тус сургууль нь англи хэлний сургалтаа үндсэн 3 үе шаттайгаар явуулдаг байна.

1. Эхний 2 курст ярианы англи хэлний сургалтыг явуулдаг (speaking practice) - (Багшийн хувьд унаган англи хэлтэй гадаад багшийг санал болгодог)
2. Англи хэлний түвшин сайжирч 700-750 оноо авсан тохиолдолд TOEIC буюу олон улсын ажлын байрны англи хэлний шалгалтанд зориулсан сургалтын хөтөлбөрийг санал болгодог - (Солонгос багш хичээл заах эрхтэй)
3. CEO - Chief Executive officer - ажлын байрны англи хэлийг заах ба энэ түвшинд presenting skill буюу илтгэх ур чадварыг мөн голлон анхаардаг - (Багшлах багш нь солонгос болон гадаад багш нар байдаг).

МУБИС-ийн гадаад хэлний сургалтын хувьд элсэн орж байгаа нэгдүгээр курсийн оюутнуудаас түвшин тогтоох шалгалт авч 2 түвшин болгон ангилж түвшин бүрт тохирсон хөтөлбөрийг багш нар өөрсдөө зохиодог төдийгүй оюутнуудын эзэмшиж буй мэргэжил тус бүрээр нь мэргэжлийн англи хэлний хөтөлбөр бэлтгэн түүнд тохирсон ном сурах бичиг, холбогдох материалуудыг боловсруулж байна. Эрдмийн англи хэлний сургалтын хувьд ч гэсэн магистрантуудыг англи хэлний мэдлэгийн түвшингээр нь ангилж, түвшин бүрт тохирсон сургалт явуулдаг, докторантуудад академик түвшиний хөтөлбөрийг санал болгодог



зэргээс үзэхэд тус сургуулийн гадаад хэлний сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлж, оюутны хэрэгцээ шаардлагад нийцүүлээд зогсохгүй тэдгээрийн мэдлэгийн түвшинд тохирсон сургалт явуулдаг хэмээн үзэж болохоор байна.

Судлаач Н.Оюунцэцэг (2011) “Мэргэжлийн чиглэлийн англи хэлний сургалтын хөтөлбөр нь хэлний мэдлэгт төвлөрсөн, чадварт төвлөрсөн болон сурахуйд төвлөрсөн гэсэн 3 үндсэн хэлбэрүүдтэй байдаг хэмээн ангилжээ”. (х.29)

Түүнчлэн мэргэжлийн чиглэлийн англи хэлний нарийвчилсан хөтөлбөр нь:

- Сэдэвт тулгуурласан
- Үүрэг болон утгад суурилсан
- Чадварт суурилсан
- Нөхцөлд суурилсан
- Даалгаварт суурилсан
- Чадвар болон дискурст суурилсан
- Чадвар болон арга техникт суурилсан гэсэн загваруудтай байж болдог.

**Мэргэжлийн англи хэлний хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ анхаарх зүйлс:**

### **1. Суралцагчдын сурах онцлогийг харгалзан үзэх**

Мэргэжлийн англи хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулахад анхаарах өөр нэг чухал асуудал бол суралцагчдын сэтгэл зүй, суралцах арга барилын онцлогийг анхааран үзэх явдал юм. Энэ нь Монгол хүний суралцах арга барил, зан чанарын онцлогийг харгалзан үзэх гэсэн санаа агуулагдаж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл бид гадны сургалтыг шууд хуулбарлаж, хүчээр тулгаж ирсэн нь ямарваа нэгэн шинэлэг санааг үгүйсгэх нэгэн хүчин зүйл хэмээн үзэж болно.

### **2. Хөтөлбөр боловсруулах багийг бүрдүүлэх**

Хөтөлбөр боловсруулах багийг нарийн зохион байгуулах хэрэгтэй болно. Тухайн багт мэргэжлийн чиглэлийн англи хэл заадаг багш нараас гадна, сургуулийн сургалтын бодлогыг хариуцан ажилладаг мэргэжилтэн, мэргэжлийн салбарын багш нарыг төлөөлөл болон оролцуулах, мөн хөтөлбөр боловсруулах туршлага бүхий энэ чиглэлээр

сурдалгаа хийсэн, хийж байгаа, сургалт зохион байгуулж байсан туршлагатай мэргэжилтэн зэрэг төлөөллийг оролцуулдаг байх нь зүйтэй.

### **3. Ном сурах бичгийн талаар судалгаа хийх**

Мэргэжлийн англи хэлний сургалтыг зохион явуулахад шаардагдах ном, сурах бичгийн хувьд англи хэл дээрх ном бүтээлийн зэрэгцээ өөрсдийн багш нарын туурвисан ном, гарын авлага чухал үүрэг гүйцэтгэх болно. Тиймээс мэргэжлийн англи хэлний чадвар тус бүрээр уншиж ойлгох, бичих, орчуулах, чадварыг багтаасан мэргэжлийн ном бэлтгэж цаашид сургалтад хэрэглэх нь сургалтын үр дүнд эерэгээр нөлөөлнө.

### **4. Англи хэлний түвшин тогтоох шалгалтын системийг боловсронгуй болгох**

Мэргэжлийн англи хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорьж байгаа тохиолдолд ерөнхий англи хэлний сургалтыг дуусгаад, мэргэжлийн англи хэлний сургалтад шилжихийн өмнө өгдөг шалгалт байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл бид суралцагчдыг англи хэлний тодорхой түвшинд хүрсэн тохиолдолд мэргэжлийн англи хэлний сургалтыг эхлүүлдэг системийг нэвтрүүлэх нь чухал байна.

### **5. Багш нарт сургалт, семинар зохион байгуулах**

Мэргэжлийн англи хэлний сургалтыг зохион байгуулах багш нарт мэргэжлийн англи хэлний сургалтын хөтөлбөрийн талаар, сурах бичиг, заах арга зүй, орчин үеийн техник технологийн дэвшлийг сургалтад нэвтрүүлэх, хичээлийн бэлтгэл ажлыг хангах үүднээс сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

### **6. Сургалтын орчин бүрдүүлэх**

Мэргэжлийн англи хэлний сургалт нь багаар ажиллах, илтгэл хэлэлцүүлэх, мэтгэлцэх, хурал зохион байгуулах зэрэг олон арга хэлбэрээр явагддаг тул түүнд тохирсон ширээ сандал анги, танхим бүхий проектор болон техник хэрэгсэл ашиглах

боломжтой, дуу чимээнээс тусгаарлагдсан, сонсголын хичээл явуулахад тохиромжтой сургалтын орчин бүрдүүлэх нь сургалтад эерэгээр нөлөөлдөг байна.

### ДҮГНЭЛТ

1. БСШУЯ-ны яам, их, дээд сургуулийн консорциум, бусад холбогдох байгууллагууд анхаарч мэргэжлийн англи хэлний нэгдсэн стандарт, хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх удирдамж боловсруулах шаардлагатай байна.
2. Мэргэжлийн англи хэлний хөтөлбөрийн цөм нь хэрэгцээг тодорхойлох судалгаа бөгөөд энэхүү судалгааг суралцагч, ажил олгогч хийгээд нийгмийн хэрэгцээг тодруулах үүднээс өргөн хэмжээнд зохион байгуулах хэрэгтэй.
3. Мэргэжлийн англи хэлний болон ерөнхий англи хэлний сургалтын хөтөлбөр хийгээд нарийвчилсан хөтөлбөр хоорондын ялгааг тодруулж, тэдгээрийн олон талт хувилбарыг сургалтад нэвтрүүлэх нь сургалтыг үр дүнтэй явуулахад дөхөмтэй байх болно.
4. Оюутны хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, ажлын байрны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын байгууллагад ажиллах, англи хэлний олон улсын дундаж түвшин эзэмшүүлэх, төрийн бодлоготой уялдуулах үүднээс МУБИС-ийн удирдлагын зүгээс мэргэжлийн англи хэлний цагийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч заавал судлах хичээл болгох.
5. Хөтөлбөр боловсруулах багийг бүрдүүлэх.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Hutchinson, T., & Waters, A. (1991). *English for Specific Purposes (6<sup>th</sup> ed.)*. United Kingdom, UK: Cambridge University Press.
- Locke, W., Cummings, W.K., & Fisher, D. (Eds.). (2011). *Changing Governance and Management in Higher Education (1<sup>st</sup> ed.)*. London, New York, NY: Springer

Paltridge, B., & Starfield, S. (Eds.). (2014). *The handbook of English for Specific Purposes (1<sup>st</sup> ed.)*. Oxford, UK: Vivar printing

Зэгиймаа, Ч., нар. (2012). *Монгол улсын хэлний бодлого ба хэл төлөвлөлт(эмхэтгэл)*. Улаанбаатар: Бэмби сан хэвлэлийн газар

БСШУЯ. (1998). *Гадаад хэлний боловсролын стандарт*. Улаанбаатар.

Монголын англи хэлний багш нарын холбоо. (2009). *Англи хэлний боловсролын тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам*. Улаанбаатар: Адмон хэвлэлийн газар.

Оюунцэцэг, Н. (2011). *Мэргэжлийн англи хэлний сургалтын хөтөлбөрийн инноваци* (диссертаци). Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Улаанбаатар.

Пүрэвдорж, Ч. (2009). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар.